



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Амгалан дулааны станц” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 306,350,000.00 (гурван зуун зургаан сая гурван зуун тавин мянган) төгрөгийн балансын үнэтэй, 23,168,404.96 (хорин гурван сая нэг зуун жаран найман мянга дөрвөн зуун дөрвөн төгрөг ерэн зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг “Багануур дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Батгэрэл, “Амгалан дулааны станц” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх, “Багануур дулааны станц” төрийн өмчит хувьцаат компанийн захирал Н.Ганбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

00000002

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 8 дугаар сарын 7-ны өдрийн
08 дугаар тогтоолын хавсралт

"АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ" ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИАС "БАГАНУУР ДУЛААНЫ СТАНЦ" ТӨРИЙН
ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Бульдозер, 04-28 УН, У102286	2018/2018	ш	1.00	306,350,000.00	23,168,404.96	283,181,595.04
Нийт дүн				306,350,000.00		23,168,404.96	283,181,595.04
				(Гурван зуун зургаан сая гурван зуун тавин мянган)		(хорин гурван сая нэг зуун жаран найман мянга дөрвөн зуун дөрвөн төгрөг ерэн зургаан мөнгө)	(хоёр зуун наян гурван сая нэг зуун наян нэгэн мянга таван зуун ерэн таван төгрөг дөрвөн мөнгө)